

рио цээр болон хязгаарлалтын дэглэм тогтоосон энэ үед ҮБХИС-ийн зарим бие бүрэлдэхүүн халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан одор тутмын үүргээ амжилттай гүйцэтгэж байгаа юм. Тэдний нэг хэсэг болох Харуул үйлчилгээний ротын нийт бие бүрэлдэхүүнд оноодор БХЭШХ-ийн судлаач эрдэмтдээс 500 ширхэг амны хаалт бэлэглэлээ. Монгол эх орныхоо онцог булан бүрээс эр цэргийн үүргээ үнэнчээр биелүүлэхээр ирсэн цэрэг дайчиддаа албаа нэр төртэй сайн хааж, халдвар хамгаалалтын дэглэмээ чанд баримтлан үүргээ гүйцэтгэхийг хурандаа Т.Соронзонболд хүсэн ерөөв.

